*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# САНГИЙН БҮРТГЭЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН СҮХБААТАРЫН БЯМБААГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **ЗОРИЛТ 1. “ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ”** | | | | | | | |
| 1.1 | Сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг иж бүрэн гаргаж, холбогдох албан тушаалтнаар хянуулан баталгаажуулж, хугацаанд нь хүргүүлэх, | Мэдээ тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | Сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж хүргүүлсэн. | Сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь хүргүүлэх | Нийгмийн даатгалын сарын мэдээ, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, өглөгийн мэдээ, нийгмийн даатгалын хамралт, тэтгэвэр тэтгэмж авагчдын мэдээг сар бүрийн 2-ны дотор ерөнхий нятлантай хамтран цаг хугацаанд нь үнэн зөв гаргахад хамтран ажилласан. Тайлант хугацаанд 6 удаа сарын мэдээг дамжуулсан байна. | 2025.01.01<br>2025.12.31 | |
| 1.2 | Сангийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлийг тооцож, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах санал гаргах, | Сангийн төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна | Төсвийн хуваарийн санал хүргүүлсэн. | Батлагдсан төсвийн хуваарийг мөрдөж төсвийг хэтрүүлэлгүй ажилласан байна. | Хагас жилийн байдлаар нийгмийн даатгалын батлагдсан төсвийн хэтрэлт хэмнэлтийг авч үзэхэд:<br>• Тэтгэмжийн сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 26,378.8 мянган төгрөг,<br>• ҮОМШӨ-ны сангаас 31,488.4 мянган төгрөг, | 2025.01.01<br>2025.12.31 | |

1273

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • Ажилгүйдлийн даатгалын сангаас 323,781.5 мянган төгрөгийн тэтгэмжийг батлагдсан хуваариас илүү олгосон байна.<br>Дээрхи сангийн зардлуудаас ажилгүйдлийн тэтгэмж сангийн зардал зарцуулах төсвөөс хэтэрсэн ба тэтгэмжийн сан болон ҮОМШӨ-ны сангийн зардал сан дотороо хэтрэлтгүй олгогдсон.<br><br>Ажилгүйдлийн даатгалын сангийн зардлын хэтрэлттэй холбоотой НДЕГ-ын санхүү бүртгэл хөрөнгө оруулалтын газарт тус газар 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 3,622.1 сая төгрөгийн бодит хэрэгцээ үүсэх төлөвтэй буй, талаар урьдчилан мэдэгдэж, төсвийн зохицуулалт хийж өгөх талаар албан тоот хүргүүлсэн. | | |
| 1.3 | Шилэн дансанд оруулах мэдээллийг хуулийн хугацаанд оруулах | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байна. | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулсан. | Тухай бүр | Шилэн дансны цахим системд нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, батлагдсан төсөв, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, нийгмийн даатгалын сангаас олгож буй тэтгэвэр тэтгэмж, төлбөр авагчдын тоо, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг тус тус pdf, хүснэгтэн хэлбэрээр сар бүр хуулийн хугацаанд үнэн зөв байршуулан ажиллаж байна.<br><br>Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 43,148,641.2 мянган төгрөг, зарлагын 65,665,773.1 мянган төгрөгийн мэдээллийг 7 хоног бүр тогтмол | 2025.01.01<br>2025.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байршуулан мэдээллээр хангаж ажиллаж байна.<br>Шилэн дансны мэдээлэлд:<br>• Тухай бүр – 9 мэдээллийг 6 удаа<br>• Сар бүр – 3 мэдээллийг 6 удаа<br>• Хагас жил – 4 мэдээллийн хугацаа болоогүй,<br>• Жил бүр –11 мэдээллээс хугацаа нь болсон 4 мэдээлэл<br>Хавсралт файл – 6 мэдээлэл нийт 82 мэдээллийг байршуулсан байна. | | |
| 1.4 | Сангийн бүртгэл хөтлөх, программ хангамжийг боловсронгуй болгох санал боловсруулах, | Сангийн бүртгэл сайжирсан байна. | - | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. | SICOS системийн нягтлан бодох бүртгэл, мэдээллийн уялдаа холбоог сайжруулахад анхаарч мэдээ тайланг цаг хугацаанд нь гаргах нөхцлийг бүрдүүлэн ажиллав.<br><br>Мөн мэдээллийн системийн хөгжүүлэлтийн хүрээнд нягтлан бодох бүртгэл цэсэнд үүсч буй алдаа, шаардлагатай сайжруулалт хийх саналыг системийн сайжруулалтыг хариуцаж буй ажлын хэсэгт хүргүүлээд байна.<br><br>Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалтын дагуу бүтээгдэхүүн үйлчилгээний орлого зарлагын ажил гүйлгээ бүрийг холбогдох анхан шатны нотлох баримт, харилцах дансны хуулгыг үндэслэн бүртгэж байна.<br><br>Системийн сайжруулалттай холбоотой санал хүсэлтийг байцаагч ажилтнуудтай хамтран гаргаж 2 удаа хүргүүлээд байна. | 2025.01.01<br><br>2025.12.31 | |
| **ЗОРИЛТ 2. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ** | | | | | | | |
| 2.1 | Сангийн орлого хуримтлуулдаг болон сангийн харилцах данс | Сангийн нягтлан бодох | Сангийн орлогын гүйлгээг | Сангийн орлогын гүйлгээг цаг | Нийгмийн даатгалын мэдээллийн цахим системд эхний хагас жилийн байдлаар 890 ажил олгогчоос 32,634,896.1 мянган төгрөг, 3516 сайн дурын | 2025.01.01<br>2025.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүрээр орлогын гүйлгээг анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, мэдээллийн нэгдсэн санд тухай бүр үнэн зөв бүртгэх | бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдсөн байна. | анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, үнэн зөв бүртгэсэн. | тухай бүрт үнэн зөв бүртгэсэн байна. | даатгуулагчийн 1,362,292.4 мянган төгрөгийн шимтгэлийн орлого бүртгэгдсэн байна. Ажил олгогч, даатгуулагчийн шилжүүлсэн нийт 19488 удаагийн гүйлгээ буюу 33,997,188.5 мянган төгрөгийн шимтгэлийн орлогыг таниулж, үнэн зөв бүртгэн мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаа. Мөн нийгмийн даатгалын шимтгэл төлж буй иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмжийг анхан шатны баримтын бүрдлийг үндэслэн хуулийн хугацаанд олгож зардлыг мэдээллийн баазад тухай бүр нь бүртгэн тэтгэвэр тэтгэмжүүдийг хааж мэдээллийг бүртгэн ажилласан. | | |
| 2.2 | Сангийн төлөвлөгөөний сарын хуваарийн дагуу төв сангаас санхүүжилт авч, сар бүр тооцоо нийлэх, | Сангийн төлөвлөгөөний биелэлт хангагдсан байна. | 96,764,032.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан. | Тухай бүр | Эхний хагас жилийн байдлаар улсын төсвийн санхүүжилтийн 20,642,049.0 мянган төгрөг, дотоод санхүүжилтийн 35,521,376.2 мянган төгрөг, төвлөрүүлэлтийн 33,767957.6 мянган төгрөгийн тооцоо нийлсэн актыг үйлдэн НДЕГ-ын холбогдох мэргэжилтэнтэй тулган баталгаажуулсан.<br>• Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангаар үүссэн өглөг, авлагын тооцоог тус газрын холбогдох байцаагч нартай жагсаалт үйлдэн тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан.<br>• Тайлант хугацаанд төсвийн байгууллагын нягтлан бодогчдын шимтгэлийн орлогын өглөг, авлагын тооцоо нийлсэн актыг тулган баталгаажуулсан байна.<br><br>• Нийгмийн даатгалын сангийн харилцах дансны үлдэгдэл, хүүгийн орлогын дүнг арилжааны банктай тулган тооцоо нийлсэн актыг үйлдэж баталгаажуулсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3 | Арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу төвлөрсөн болон сангийн харилцах дансны өдөр тутмын хүүгийн орлогын тооцоог хийж, харилцах дансны хүүгийн тооцоонд хяналт тавьж, улирал бүр харилцагч банкаар баталгаажуулах, | Гэрээний заалт хангагдсан байна. | Арилжааны банкуудтай тооцоо нийлж, баталгаажуулсан. | Арилжааны банкуудтай хүүгийн орлогын тооцоо нийлсэн акт үйлдсэн байна. | | 2025.01.01 2025.12.31 | |
| 2.4 | Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл, Улсын байцаагчийн актаар төлсөн шимтгэл, алданги, торгуулийн дүнг хариуцсан албан тушаалтантай тогтоосон хугацаанд тулган хянан баталгаажуулах, | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна. | Акт, алданги, торгуулийн дүнг хариуцсан албан тушаалтантай тулган хянан баталгаажуулсан. | Хариуцсан албан тушаалтантай тулган хянан баталгаажуулна. | Нийгмийн даатгалын цахим мэдээллийн системд Нийгмийн даатгалын төвлөрсөн харилцах дансанд улсын байцаагчийн актаар төлсөн шимтгэл, алданги, торгуулийн дүнг холбогдох байцаагчтай тухай бүр тулган даатгуулагч дээр танигдсаныг залруулж, ажил олгогчийн регистрээр зөв болгон таниулан ажиллаж байна. | 2025.01.01 2025.12.31 | |
| 2.5 | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах, | Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно. | Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг | 228,631,431.3 мянган төгрөг | Нийгмийн даатгалын сангийн зардлын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан хагас жилийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 77,095,165.1 мянган төгрөг зардал төсөвлөснөөс 74,999,332.0 мянган төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, ҮОМШӨ, ажилгүйдлийн даатгалын сангаас зардлуудыг шилжүүлж 2,095,833.1 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэн үзүүлэлттэй байна. Үүнийг сан тус бүрээр авч үзвэл: | 2025.01.01 2025.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хугацаанд нь олгосон. | | Тэтгэврийн даатгалын сангаас – 69,764,943.5 мянган төгрөг<br>Тэтгэмжийн даатгалын сангаас 2,823,785.0 мянган төгрөг<br>ҮОМШӨ-ны даатгалын сангаас 362,222.0 мянган төгрөг<br>Ажилгүйдлийн даатгалын сангаас 2,048,381.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. | | |
| 2.6 | Нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн харилцах дансны орлогыг тогтмол төвлөрүүлэх, | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ. | 78,178,251.1 мянган төгрөгийн төвлөрсөн сангийн харилцах дансны орлогыг төвлөрүүлж, тооцоо нийлсэн. | 116,009,957.6 мянган төгрөг | Нийгмийн даатгалын сангийн төрийн сангийн төвлөрсөн орлогын харилцах дансны үлдэгдлийг өдөр бүр төрийн сангийн удирдлагын цахим системээр дамжуулан нийт 15,985,651.9 мянган төгрөгийн төвлөрүүлэлтийг хийсэн байна.<br>Арилжааны банктай хамтран ажиллах гэрээний 3.3 дахь заалтын дагуу банкны төвлөрсөн орлогын харилцах дансны үлдэгдлийг өдөр бүр автомат таталт хийж 17,191,489.1 мянган төгрөгийн төвлөрүүлэлт хийгдсэн байна.<br>Арилжааны банкинд төлбөрийн хүсэлтээр 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс 6 дугаар сарын 6-ны өдрийн хооронд 590,816.6 мянган төгрөгийн төвлөрүүлэлтийг НДЕГ-ын төв төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлсэн байна. | 2025.01.01<br>2025.12.31 | |
| 2.7 | Харилцах дансны үлдэгдлийг тогтоосон хугацаанд баталгаажуулах, | Төрийн сан, арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдлийг үнэн зөв баталгаажуулсан байна. | Харилцах дансны үлдэгдлийг улирал, хагас, бүтэн жилээр тооцоо нийлж ажилласан. | Хагас жил | Нийгмийн даатгалын сангийн төрийн сан болон арилжааны банкны харилцах дансны үлдэгдлийн дүнг улирал бүр холбогдох мэргэжилтэнтэй тулган тооцоо нийлсэн актыг үйлдэж баталгаажуулсан. | 2025.01.01<br>2025.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.8 | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажиллах, | Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ. | Өөрчлөлтгүй дүгнэлт авсан. | Аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авах. | Төрийн аудитын газраас нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан.<br>Нийгмийн даатгалын санд хийсэн аудитаар 3 зөвлөмж, 1 албан шаардлагын санал дүгнэлтийг хүлээн авч зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган аудитын байгууллагад хүргүүлсэн. Ажлын төлөвлөгөөний дагуу зөвлөмжийн биелэлтийг ханган ажиллаж байна. | 2025.01.01<br>2025.12.31 | |
| 2.9. | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн төсөл, төсөөллийн санал боловсруулан НДЕГ-т хүргүүлэх | Төсвийн тухай хууль болон холбогдох журам зааврыг хэрэгжилт | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн төсөл, төсөөллийн саналыг тогтоосон хугацаанд боловсруулан НДЕГ-т хүргүүлсэн. | Хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн үзүүлэлт хоорондын уялдааг хангасан төсвийн санал боловсруулагдсан байна. | Газрын даргын 2025 оны А/05 дугаар тушаалаар төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны дунд хугацааны төсөөллийн саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/72 дугаар тушаалаар баталсан төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахад баримтлах заавар, журмын дагуу боловсруулж, хуулийн хугацаанд хүргүүлсэн. Үүнд:<br>-Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөллийн саналыг ажлын хэсгийн гишүүд боловсруулахдаа цэрэг, цагдаа, онцгой, шүүхийн байгууллага, аймгийн боловсролын газар, эрүүл мэндийн газарт албан бичиг хүргүүлснээр ажил олгогч, даатгуулагчдын нийт цалин хөлс, ажилчдын тоо, өндөр насны тэтгэвэрт гарах судалгаа, нийгмийн даатгалд хамрагдах ажил олгогчдын тоо, 0-3 насны хүүхдээ харж буй эхчүүдийн судалгаа, мэдээлэлд үндэслэсэн байна. | 2025.07.01<br>2025.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -13 сумдын нийгмийн даатгалын байцаагчдад төсвийн төсөл боловсруулах албан бичгийг хүргүүлсэнээр сумын нийгмийн даатгалын төсвийн төсөл, төсөөллийн саналыг хүлээн авч нэгтгэн хүргүүллээ. | | |
| **ЗОРИЛТ 3. "ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 3.1. | Нэгжийн үйл ажиллагааны зорилтыг хангахад чиглэсэн өөрийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх арга хэмжээ авах, | Холбогдох хууль тогтоомжийн дагуу хийсэн байна. | Гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтийг хугацаанд нь гаргаж тайлагнасан. | Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хугацаанд нь гаргаж тайлагнасан байна. | Төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Санхүү бүртгэл хамралт, орлогын хэлтсийн даргаар батлуулж, эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь гаргаж хянуулсан. | 2025.01.01 2025.12.31 | |
| 3.2 | Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүр гаргаж өгөх, тайлагнах, | Мэдэгдлийг тухай бүр гаргаж тайлагнасан байна. | ХАСХОМ хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж мэдүүлсэн. | ХАСХОМ гаргах, өөрчлөлтийг цаг хугацаанд нь гарган мэдүүлэх | ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд шинэчлэн гаргасан. | 2025.01.01 2025.12.31 | |
| 3.3 | Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь хүргүүлж ажиллах, | Хугацаанд нь хүргүүлэх, -Баримтын чанар, үзүүлэлт тодорхой байна. | Дээд газраас өгсөн хугацаатай үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хүргүүлж ажилласан. | | НДЕГ-аас ирүүлсэн хугацаатай 19 албан бичгийн хариуг хүргүүлэн ажилласан байна. | 2025.01.01 2025.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4 | Албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, баримт бичгийн стандартыг хэрэгжүүлж ажиллах, бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу жилийн эцэст архивд хүлээлгэн өгөх, | Холбогдох хууль тогтоомжийн дагуу чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. | Хуулийн хугацаанд хүлээлгэн өгөх 75 боть баримт хүлээлгэн өгсөн. | Албан хэрэг хөтлөлт, архивын баримт холбогдох стандарт, зааварт нийцүүлэн ажилласан байна | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн 80 ширхэг баримтыг хадгаламжийн нэгж болгон үүсгэж архив, хөрөнгө хариуцсан ажилтанд бүртгүүлж, жагсаалтаар хүлээлгэн өгсөн. | 2025.01.01<br>2025.12.31 | |
| 3.5 | Удирдлагын өгсөн үүрэг даалгавараар ажил гүйцэтгэх, танилцуулах, шаардлагатай тохиолдолд ажил орлон гүйцэтгэх | Тухай бүр гүйцэтгэж, шаардлагатай тохиолдолд ажил орлон гүйцэтгэсэн байна. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. | | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын судалгаа, мэдээллийг удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу цаг тухай бүрт нь хугацаа хоцроолгүй хэрэгжүүлэн ажиллаж байна. | 2025.01.01<br>2025.12.31 | |
| 3.6 | Олон нийтийн арга хэмжээнд оролцох, зохион байгуулах | Зохион байгуулагдсан ажилд идэвхтэй оролцсон байна. | Олон нийтийн арга хэмжээнд идэвх санаачлагатай оролцсон. | Зохион байгуулсан ажилд тогтмол оролцох | Байгууллагын залууд болон удирдлагаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээ, тэмцээн уралдаанд идэвх санаачлагатай оролцож байна. | 2025.01.01<br>2025.12.31 | |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН БИЕЛЭЛТ**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|

**ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үндэсний монгол бичгийн мэдлэг чадвараа сайжруулах | Монгол бичгээр уншиж бичих мэдлэгийн хүрээгээ бодит алхамаар дээшлүүлж үр дүнг тодорхойлсон байна. | НДЕГ-аас зохион байгуулсан монгол бичгийн цахим сургалтад хамрагдсан. | Үндэсний монгол бичгийн цахим бичвэрийн сургалтад хамрагдана. | Үндэсний монгол бичгийн мэдлэг чадвараа сайжруулах цахим бичвэрийн сургалтад 3 дугаар улиралд хамрагдана. | 2025.07.01<br>2025.12.31 | |
| 2. | Нягтлан бодогчийн мэргэжлийн сургалтад хамрагдах, | Мэргэжлийн сургалтад | - | ММНБИ-ээс зохион байгуулсан мэргэжлийн сургалтад хамрагдана | Нягтлан бодогчийн мэргэжлийн сургалтад хамрагдана. | 2025.01.01<br>2025.12.31 | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

САНГИЙН БҮРТГЭЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ............................ С.БЯМБАА 2025.06.15